



# УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК

Монгол Улс, Улаанбаатар хот-210136, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо,  
Чингисийн өргөн чөлөө-67/1, "Номин юнайтед" төв, 5 дугаар давхар  
Утас: (976-11) 319292, Факс: (976-11) 319393  
И-мэйл: [sds@nomin.net](mailto:sds@nomin.net)

2021 оны 04 дүгээр  
сарын 30-ны өдөр

№ 01

Улаанбаатар  
хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

ТУЗ-ийн дүгнэлт болон ТУЗ-ийн  
2021 оны зардлын төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.16 дахь хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:


1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг Хавсралт №-ээр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



С.САЙНБАТ

“Улсын их дэлгүүр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 30-ны өдрийн ээлжит хурлын 01 тоот тогтоолын Хавсралт №1



**Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2021 оны зардлын төсөв**

(мянган төгрөгөөр)

1. Гишүүдийн цалин, НДШ /9 хүн*75,0 мян.төг*12 сар/	10,215.0
2. НБ-н даргын цалин, НДШ /75,0 мян.төг*12 сар/	1,021.5
3. ТУЗ-ийн хурлын зардал	2,100
4. Тархалтын судалгаа, бичиг хэрэг, нотариатын зардал	400.0
5. Унааны зардал	300.0
<b>Нийт дүн</b>	<b>14,036.5</b>



# УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК

Монгол Улс, Улаанбаатар хот-210136, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо,  
Чингисийн өргөн чөлөө-67/1, "Номин юнайтед" төв, 5 дугаар давхар  
Утас: (976-11) 319292, Факс: (976-11) 319393  
И-мэйл: [sds@nomin.net](mailto:sds@nomin.net)

2021 оны 04 дүгээр  
сарын 30-ны өдөр

№ 02

Улаанбаатар  
хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, компанийн дүрмийн 7.3.4 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг сонгосугай. Үүнд:
  - 1.1. Янсанжавын Наваан
  - 1.2. Санжаагийн Сайнбат
  - 1.3. Идэштогтохын Галбуян
  - 1.4. Алтангэрэлийн Норсмаа
  - 1.5. Тэрбишийн Сарантуяа
  - 1.6. Хүрэлхүүгийн Эрдэнэбаатар
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг сонгосугай. Үүнд:
  - 2.1. Намсрайн Батцацрал
  - 2.2. Дашдондогийн Дашцэдэн
  - 2.3. Пүрэвийн Эрдэнэболд
3. Холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм, дотоод үйл ажиллагааны дүрэм, журам зэрэг компанийн засаглалын тогтолцооны эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллахыг шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
4. Шинээр томилогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаарх мэдээллийг холбогдох эрх зүйн актад тусгасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид тус тус мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Өлзийбат/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С.САЙНБАТ



# УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК

Монгол Улс, Улаанбаатар хот-210136, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо,  
Чингисийн өргөн чөлөө-67/1, "Номин юнайтед" төв, 5 дугаар давхар  
Утас: (976-11) 319292, Факс: (976-11) 319393  
И-мэйл: [sds@nomin.net](mailto:sds@nomin.net)

2021 оны 04 дүгээр  
сарын 30-ны өдөр

№ 03

Улаанбаатар  
хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын  
санал хураалтыг хүчингүйд тооцох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.11, 62.1.15 дахь хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04-р сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- Компанийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсэн дор дурдсан асуудлуудын санал хураалтыг хүчингүйд тооцож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлүүлэхээр тогтоосугай. Үүнд:
  - "Номин реалтор" ХХК-тай байгуулсан Барилгын ажлын захиалагчийн эрх, үүргийг шилжүүлэх гэрээтэй холбоотой сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах.
  - Арилжааны банкнаас бага хүүтэй зээл авч, одоо байгаа зээлийг хаах, нэмэлт хөрөнгө оруулалтанд зарцуулах, Улсын их дэлгүүрийн барилгыг гуравдагч этгээдэд барьцаалуулах эрхийг "Номин холдинг" ХХК-д шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу зарлан хуралдуулж, энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасан асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С.САЙНБАТ